

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ 5 ДУГААР ХУРАЛДААН**

Хуралдаан 2016 оны дөрөвдүгээр сарын 06-ны 11 цаг 45 минутад эхэлж, 12 цаг 55 минут хүртэл Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн даргын өрөөнд болж, нийт 1 цаг 10 минут үргэлжлэв.

№	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	Шийдвэр
1.	Төрийн албаны зөвлөлийн 20 жилийн ойг угтсан ажлын төлөвлөгөөг хэлэлцэж батлах	Төрийн албаны зөвлөлийн 20 жилийн ойг угтсан ажлын төлөвлөгөөг хэлэлцэж, 20 бүтээлч ажил хийхээр төслийг батлав.
2	Адаацаг сумын Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын ажилтны захиалгын дагуу сул орон тоонд нөөцөөс нэр дэвшүүлэх тухай	Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд тус аймгийн Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтанд 63,6 оноо авч, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 196 дугаар тогтоолоор төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Батчулуун овогтой Дэлгэрмандахыг нэр дэвшүүлэхээр шийдвэрлэв.
3.	Салбар зөвлөлүүдийн 2015 оны үйл ажиллагааны тайланд хийсэн үнэлгээний дүнг хэлэлцээд салбар зөвлөлүүдэд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэлэлцэж батлах	Төрийн албаны зөвлөлөөс Салбар зөвлөлүүдийн 2015 оны үйл ажиллагааны тайланд хийсэн үнэлгээний дүнг хэлэлцээд салбар зөвлөлүүдэд өгсөн зөвлөмжийг аймагт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэлэлцэж батлав.
4.	Дэлгэрцогт сумын ЗДТГ-ын мэргэжилтний албан тушаалд нэр дэвшсэн Г.Бадамцэцэгийн өргөдлийг хэлэлцээд Адаацаг сумын ЗДТГ-ийн мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	Адаацаг сумын Мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологи, үржил бүртгэл хариуцсан мэргэжилтний албан тушаалд Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтанд 67,6 оноо авч, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 03 сарын 15-ны өдрийн 32 дугаар тогтоолоор төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Гантулга овогтой Бадамцэцэгийг томилуулахаар нэр дэвшүүлэв.
5	Хөдөлмөрийн хэлтсийн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөр хариуцсан мэргэжилтний албан тушаалд нөөцөөс нэр дэвшүүлэх тухай	Хөдөлмөрийн хэлтсийн Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөр хариуцсан мэргэжилтний албан тушаалд тус аймгийн Төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн Сумъяа овогтой Бямбамааг томилуулахаар нэр дэвшүүлэв.
6	Төрийн албаны салбар зөвлөлөөс сум байгууллагуудад хүргэх зөвлөмжийн төсөл хэлэлцэж батлах	Төрийн албаны стандартын хэрэгжилт, ёс зүйн хороодын тайланг аймгийн төрийн албаны салбар зөвлөлийн хурлаар хэлэлцээд гаргасан зөвлөмжийг баталж, Зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг сум, байгууллагынхаа хэмжээнд төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, үр дүнг холбогдох хугацаанд тооцон тайлагнаж байх чиглэлийг албан тоотоор хүргүүлэхээр болов.

САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА